



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад "төсөв" гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц байхаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад "дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл" гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг байхаар, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхээр тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Энэхүү хуулийн төсөлд нүүрсний экспортыг 2024 онд 50 сая тонн байхаар тусгасан хэдий ч Засгийн газраас хэрэгжүүлж буй "Боомтын сэргэлт" ийн хүрээнд хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортыг эрчимжүүлэх арга хэмжээний үр дүнд 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нүүрсний экспорт 52 сая тоннд хүрэхээр байна.

Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тооцсон нүүрсний экспортын биет хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлэн, 60 сая тоннд хүргэх бололцоотой байна. Түүнчлэн, Оюутолгойн гүний уурхайн олборлолт явагдаж, зэсийн баяжмалын агууламж өссөнөөр уул уурхай, түүнийг дагасан тээвэр логистик, худалдааны салбарын өсөлт нэмэгдэж 2024 онд 6.5 хувь гэж тооцоолж байсан эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрэх төлөвтэй байна.

Ингэснээр, экспортын орлого өсөж төлбөрийн тэнцэл сайжрах, гадаад валютын албан нөөц нэмэгдэж валютын ханш тогтворжих зэргээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд эергээр нөлөөлөхөөс гадна төсвийн орлого нэмэгдэхээр тооцлоо.

Ирэх 2024 онд Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, хот хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хөгжил дагасан бүтээн байгуулалтуудыг хийх замаар эдийн засгийн суурийг тэлэх төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн орлогыг зарцуулна.

Дээр дурдсан нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгоод байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг зөв тооцож, улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал бодитой болох юм.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

--- оОо ---